

БАТЛАВ
БАЯНХОНГОР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Ж.МӨНХСОЁЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМЫГ
2020-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ "МОНГОЛ АРДЫН НАМ"-ЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 дугаар сарын 07

Номгон

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 ОРЛОГОТОЙ ИРГЭН

1.1.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац"-аар дамжуулан бага хүүтэй зээл олгоно.

1.1.2. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

1.1.3. Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.4. Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.5. Хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.

1.1.6. Иргэдийн туршлага, ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно.

1.2 ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САН БА ОРОН СУУЦТАЙ ӨРХ

1.2.1. Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон / орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай орон сууцаар хангана.

1.2.2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж, эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.3 ЭРҮҮЛ ИРГЭН

1.3.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

1.3.2. Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдана.



000000001

1.3.3. Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон Олон Улсад цахимаар солилцдог болгоно.

1.3.4. “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.5. “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангилна/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь урьдчилан сэргийлж, “Эрүүл ирээдүй” хөтөлбөр сумандаа хэрэгжүүлнэ.

1.3.6. Эмэгтэйчүүдийн товлोलт дархлаажуулалтыг сумын хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүү, хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлж ажиллана.

1.3.7. Өрхийн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ажиллах орчин, багаж тоног төхөөрөмжийн шинэчлэл, харилцаа хандлагыг сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоно.

1.3.8. Бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэгийн халдварыг аймгийн төвийн сумдын дунджаас бууруулан, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3.9. Охидын жирэмслэлт, үр хөндөлт, төрөлтийг бууруулан өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.3.10. Ахмад настны эрүүл мэндийг дэмжиж, эмчилгээний дараах сувилахуй болон нөхөн сэргээх төрөлжсөн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.11. Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн зориулалтын зам, талбай, цогцолборуудыг байгуулж, халдварт бус өвчлөлийг бууруулан, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.


1.4. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ

1.4.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлнэ.

1.4.2. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах дохионы хэлний багш бэлтгэхэд дэмжин ажиллана.

1.4.3. Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.4. Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дэмжиж ажиллана.


000090002



Өмчлөх зөвхөн

1.4.5. “Орон нутаг дахь их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн тогтвортой үйл ажиллагааг дэмжиж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх бодлого баримталж ажиллана.

1.4.6. Эрдэнэмандал ахлах сургуулийг спортын төрөлжсөн сургууль болгон хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

1.4.7. Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.8. Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.

1.4.9. Баянхонгор сумын 2,4 дүгээр цэцэрлэгийг дахин төлөвлөлтөд оруулж барих, шинээр 3-аас доошгүй цэцэрлэг барина.

1.4.10. Сургуулиудын гадна талбайд спорт цогцолбор байгуулна.

1.4.11. Сурагчдын сурлагын амжилт, чанар, стандарт хангалтыг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлнэ

1.5 ТОГТВОРТОЙ-АМАР АМГАЛАН ГЭР БҮЛ

1.5.1. Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.2. Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

1.5.3. Хөдөлмөр эрхлэлт, зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

1.5.4. Гадаадад хөдөлмөр эрхэлж мэргэжил эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.5.5. Гэр бүл дэх эцэг, эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулна.

1.5.6 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.6. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

1.6.1. Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшилтийг сайжруулах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.6.2. Хүүхэд, багачуудын бие даах чадварыг хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр Шаргалжуут рашааныг түшиглэн хөдөлмөр зусланг байгуулна.

[Handwritten signature]

000000003



1.6.3. Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.

1.6.4. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийн замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хурд сааруулагч, камерыг засаж сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.

1.6.5. Эрүүл аюулгүй стандартын шаардлага хангасан тоглоомын газар, спортын талбайн тоог нэмэгдүүлэн хяналтыг сайжруулан ажиллана.

1.6.6 Баянхонгор суманд Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх тоглоомын талбайн тоог нэмэгдүүлнэ

1.6.7. Хүүхдийн болон ахмадын сэргээн засах сувилал байгуулна.

1.6.8. Жаргалант паркийг хүүхдийн парк болгон тохижуулна.

1.7. ЗАЛУУЧУУДЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.7.1. Залуучуудын хөгжил төлөвшилтийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7.2. Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг сайжруулах, дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7.3 Шинэ суурьшлын бүс, Залуус хорооллын шугам сүлжээг шийдвэрлэж, иргэдэд газар өмчлөх ажлыг эрчимжүүлнэ.

1.8. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ /ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ/-ТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ

1.8.1. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн нөхөн сэргээх, сэргээн засах эмчилгээний тусгай эмнэлэг, сувиллын газар байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэгш хамран сургах, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг дэмжин ажиллана.

1.8.3. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй хүүхэд, иргэдтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.9. АХМАДУУДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

1.9.1. Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төв, цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.9.2. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.

1.9.3. Ахмадын зөвлөх үйлчилгээг салбар бүрд хэрэгжүүлнэ.

1.9.4. Ахмадуудад зориулсан спорт заал барина.

[Handwritten signatures]



000000004

1.10.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ, СПОРТ

1.10.1.Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.

1.10.2.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зорилт тавин хэрэгжүүлнэ.

1.10.3.Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, биеийн тамирын арга зүйч ажиллуулна.

1.10.4.Сумын хэмжээнд ажилладаг магадлан итгэмжлэгдсэн спортын клубийг дэмжиж, хамтран ажиллана.

1.10.5.Түүх угсаатны зүйн музейн барилгыг барьж, түүх дурсгалын үзмэрүүдийг олон нийтэд таниулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.10.6.Хүүхдийн театр, хүүхдийн номын сан, хүүхдэд зориулсан бүтээл зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хөгжлийн төвүүдэд шаардлагатай сургалт, танин мэдэхүйн дэмжлэг үзүүлнэ.

1.10.7.Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлийг дэмжин хамрах хүрээг өргөжүүлж, стандартын шаардлага хангасан дугуйн замтай болно.

1.10.8.Монголын үндэсний баяр наадам, үндэсний спортын язгуур шинжийг хадгалан уламжлуулах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний спортын наадмыг зохион байгуулна.

1.10.9.Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлыг дуусгана.

1.10.10.Баянхонгор сумд Хүүхэд залуучуудын Соёлын ордон шинээр барина.

1.10.11.Баянхонгор сумд Өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор спорт цогцолбортой болно.

1.10.12.Кино театрыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж ашиглалтад оруулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1.Үйлдвэржилтийн бодлого

2.1.1.Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулж, санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.2.Сумын бие даан хөгжих эдийн засгийн нөөц бололцоог судалж, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ





000000005

2.1.3.Иргэн, айл өрх бүр хуримтлал үүсгэн эдийн засгийн хямралд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалан, өрхийн төсөв болон сум орон нутгийн эдийн засагт эергээр нөлөөлөх “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.4.Дөвөнтийн нүүрсний уурхайг түшиглэн утаагүй шахмал түлшний үйлдвэр байгуулна.

2.1.5.Барилгын чулуун материалын үйлдвэр байгуулна.

2.1.6.Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

2.1.7.Баянхонгор сумын утааг бууруулах, иргэдийн тав тухтай, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Дулааны станцыг барьж ашиглалтад оруулна.

2.1.8.Сумын төвд жижиг оврын махны үйлдвэр, мал нядалгааны цэгийг байгуулна.

2.1.9.Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулж иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.2. ТӨРӨЛЖСӨН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.2.1.Төвлөрсөн замын дагуу болон аялал жуулчлалын маршрутаар үйлчилгээний дэд бүтцийг бий болгож, ажил үйлчилгээ эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн бизнес, ажил эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.

2.2.2.Аялал жуулчлалын үйл ажиллагааг сайжруулан эдийн засгийн эргэлтэд оруулж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.2.3.Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулан үйл ажиллагааг нь өргөжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.


2.2.4.Дотоод, гадаадын жуулчдын амрах, түр буудаллах цэгийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотойгоор байгуулна.

2.3. ДЭД БҮТЭЦ

2.3.1.Утаагүй-Баянхонгор төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээнд холбож агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулна.

2.3.2.Баянхонгор сумын үерийн ус зайлуулах инженерийн байгууламжтай болно.

2.3.3.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг дахин төлөвлөлтөд оруулна.



000000006



2.3.4. Баянхонгор сумын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу гэр хорооллын эхний ээлжийг дахин төлөвлөлтөд оруулах замаар орон сууцны хороолол барих ажлыг эхлүүлнэ.

2.3.5. Баянхонгор сумын ус хангамжийн төв магистраль шугамыг солино.

2.3.6. Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг Олон Улсын төсөл хөтөлбөрийн шугамаар шийдвэрлэнэ.

2.3.7. Баянхонгор сумын гэр хорооллын айл, өрхүүдийн дунд бохирын нэгдсэн шугам татах, био жорлон нэвтрүүлэх замаар хөрсний бохирдлыг багасгана.

2.3.8. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж 200 өрхийг хамруулна.

2.3.9. 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станцын суурилагдсан хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.3.10. Эрчим хүчний яам болон шинжлэх ухааны байгууллагын боловсруулсан 10-50 Мвт-ын хүчин чадал бүхий нарны цахилгаан станцын төслүүдийг хэрэгжүүлнэ.

2.3.11. Эрчим хүчний шөнийн тарифыг тэглэнэ.

2.3.12. Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.3.13. Баянхонгор сумын Орон сууцны оршин суугчдын ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, СӨХ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.3.14. Шинэ суурьшлын бүсэд бага оврын цэвэрлэх байгууламжийг бий болгоно.


2.3.15. Шинэ суурьшлын бүс болон Залуус хорооллыг ногоон байгууламж, гэрэлтүүлэгтэй болгох, ойн зурвас, ногоон байгууламжид усалгааны систем тавина.

2.3.16. Сумын “Багшийн хөгжлийн төв” барина.

2.3.17. Баянхонгор сумын “Цахир” багт баригдаж буй багийн хөгжлийн төвийг ашиглалтад оруулж багийн иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос авах “Жишиг төв” болгон ажиллуулна. /Өрхийн эрүүл мэндийн төв, Хэсгийн байцаагч, цагдаа, Багийн хөгжлийн төв/

2.3.18. Шинэ суурьшлын бүс доторх хэсэгчилсэн төлөвлөгөөний зураг, төслийг батлуулна.

2.4. АВТО ЗАМ


000000007



2.4.1.Баянхонгор сумын төвд “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20 км авто замын ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

2.4.2.Түйн голын гарамд төмөр бетонон гүүр барина.

2.4.3.Баянхонгор сум – Шаргалжуут чиглэлийн 56 км авто замыг барина.

2.4.4. Баянхонгор сумын газар нутгийг тэлэх зорилгоор Нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх судалгааны ажлыг эхлүүлнэ.

2.4.5.Шинэ суурьшлын бүс болон Залуус хороолол, сумын төвд явган зам, дугуйн зам барина.

ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1.1.Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлж, “Орон сууц, хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.

3.1.2.Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.

3.1.3.Нийгмийн хариуцлагаа ухамсарласан, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.

3.1.4.Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.

3.1.5.Мэдээлэл технологийн шинэчлэлийг төрийн үйл ажиллагаанд тасралтгүй нэвтрүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.1.6.Хариуцлагатай төрийн албан хаагч, хариуцлагатай засаглал хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.1.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах нөхцөлийг сайжруулна.

3.1.8.Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд зориулалттай эрсдэлийн сан байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.

3.1.9.Цэрэг, эх оронч үзэлд суурилсан “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах оюутны тоог шат дараалалтай нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1.1.Баянхонгор сумын Эрдэнэмандал хайрхны орчныг цэцэрлэгжүүлж арцат, ногоон бүс болгоно.

4.1.2 Сумын төвийн оршуулгын газруудын газар олголтыг цэгцэлж, орчин үеийн шарил чандарлах технологийг нэвтрүүлнэ.

ТАВ.ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

5.1.1.Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.

5.1.2.Сум, орон нутагт иргэдийн үйлдвэрлэсэн талх нарийн боов, мах махан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр хангах "Органик хүнс" төсөл хэрэгжүүлж,өрхийн тариалалтыг дэмжиж дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангана.

5.1.3.Услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулж, төмс хүнсний ногоо, тэжээлийн болон эмийн ашигт ургамал тариалах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.4.Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй байгуулах санал, санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

Мэдээлэл бичсэн: Баянхонгор сумын Монгол Ардын Намыг төлөөлж

ДАРГА



Ж.МӨНХСОЁЛ

(Handwritten signature)



0000000000